



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/561

Улаанбаатар хот

Агентлагийн үйл ажиллагааны стратеги,  
зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн  
хөтөлбөр батлах тухай

“Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 121 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Усны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 1 дүгээр, Агентлагийн зохион байгуулалтын бүтцийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан бүтцийн дагуу зохион байгуулалт хийж, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж, хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг Усны газрын дарга /Ш.Мягмар/-д үүрэг болгосугай.

3. Тус яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар болон Туул голын сав газрын зарим чиг үүрэг, зардал, орон тоог Усны газарт шилжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Ганболд/-д зөвшөөрсүгэй.

4. Агентлагийн зохион байгуулалтын бүтэц батлагдсантай холбогдуулан дээрх хөтөлбөрт тусгасан стратегийн зорилт, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд тус газрын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны стратегийг Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу оновчтой зохион байгуулж ажиллуулахыг Усны газрын дарга /Ш.Мягмар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

011327

Байгаль орчин, аялал жуулчлалын  
Сайдын 2020 оны 12 дүгээр  
сарын 27 ны өдрийн 1/18 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

#### 1.1 Оршил

Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлно.

#### 1.2 Үндэслэл

Хөтөлбөрийг Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хууль, Усны тухай хууль, Монгол Улсын Их хурлын 2016 оны 12 дугаар, 2020 оны 121 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн боловсруулав.

#### 1.3 Эрх зүйн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Усны тухай хууль
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай
- Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030;
- Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого;
- Ус үндэсний хөтөлбөр
- Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө
- Бусад хууль тогтоомж, хөтөлбөр, бодлогын баримт бичиг.

#### 1.4 Арга зүй


Хөтөлбөрийг боловсруулахад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтад заасан ерөнхий загвар, арга зүйг удирдлага болгов.

#### 1.5 Агентлагийн үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Агентлаг нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын өмнө усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, зохистой ашиглах, усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийг шуурхай хүргэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

#### 1.6 Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч болон үйлчлүүлэгчийн бүлгийг доорх зурагт тусгаж, тэдэнд үзүүлэх үйлчилгээг бүлэг хэрэглэгчээр тодорхойлов.



Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах, усны сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлэх нэгдсэн бодлогын удирдамж, салбар дундын зохицуулалтаар хангах;

Ус ашиглагч салбарууд болон аж ахуйн нэгжүүдийг усны тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, усны нөөцийг ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээнд хэмнэлттэй, үр ашигтай ашиглуулах, дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл олгох, мэргэжлийн арга зүйгээр хангах, зөвлөгөө өгөх;

Иргэн, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагыг гадаргын болон газрын доорх ус, рашааны төлөв байдал, орон зайн үзүүлэлт, усны нөөцийн нийт болон ашиглах боломжит хэмжээ, чанар, өөрчлөлт, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалт, хаягдал ус зайлуулахтай холбогдсон мэдээ, экологи-эдийн засгийн үнэлгээ, ус хэрэглэгч, ашиглагчийн тухай мэдээлэл, хайгуул, судалгааны тайлан, усны барилга байгууламжийн байршил, хүчин чадал, техникийн үзүүлэлтийн мэдээллээр хангах;

## Хоёр. Агентлагийн үйл ажиллагааны стратеги

### 2.1 Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны бодлого болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх ажлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлэхдээ нэгдмэл арга зүйгээр усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, усны нөөцийг ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээнд хэмнэлттэй, үр ашигтай ашиглах, нөхөн сэргээх, хур тунадасны усыг хуримтлуулах, усны нөөцийг арвижуулах, хүн амын ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй хангахад оршино.

### 2.2 Тэргүүлэх чиглэл

Агентлаг нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

Усны талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;

Ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг усны талаарх мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын

байцаагч, байгаль хамгаалагчийг усны талаарх мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

### 2.3 Эрхэм зорилго

Усны талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, усны хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

### 2.4 Үйл ажиллагааны стратегийн зорилт

Агентлаг нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

2.4.1. усны нөөцийг судалж тогтоох, усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, усны сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлэх;

2.4.2.усны нөөц, түүнийг зохистой ашиглах усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйгээр хангах;

2.4.3.хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах бодлогыг дэмжих, үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэх;

2.4.4.салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөж хэрэгжүүлэх, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах

### 2.5 Үйл ажиллагааны гол зорилт

Агентлагийн үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ:

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

Усны нөөцийг судалж тогтоох, усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, усны сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлэх

2.5.1.1.Усны хайгуул, зураг төсөл, судалгааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хайгуул, судалгааны ажлын явцад хяналт тавих

2.5.1.2. Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, уг төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах;  
2.5.1.3. Гадаргын усны нөөцийг хомсдох бохирдохоос хамгаалах хууль эрх зүйн орчинг хэрэгжүүлэх, хяналт тавих.

2.5.1.4. Усны сан бүхий газар, хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих.

2.5.1.5. Усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулах

2.5.1.6. Улсын усны мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх, усны төлөв байдлын тайланг гаргах, иргэн, хуулийн этгээдийг мэдээллээр хангах

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

Усны нөөц, түүнийг зохистой ашиглах усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйгээр хангах;

2.5.2.1. Ус ашиглуулах болон усаар хангагч байгууллагад дүгнэлт гаргах, ус ашиглалтын мэдээ тайлагнах;

2.5.2.2. Сав газрын захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газрын гаргасан ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээний биелэлтэд хяналт тавих;

2.5.2.3. Голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалт зэрэг судалгаа, зураг төсөлд дүгнэлт гаргах.

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

Хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах бодлогыг дэмжих, үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэх

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

Хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах бодлогыг дэмжих, үр ашигтай хэрэглээг төлөвшүүлнэ.

2.5.3.1. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, мэдээ тайлан гаргах;

2.5.3.2. Ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл, стандартын хэрэгжилтэд хяналт тавих;

2.5.3.3. Хоногт 50 шоомтрээс их, эсхүл аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид дүгнэлт гаргах.

2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

Салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөж хэрэгжүүлэх, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулна.

2.5.4.1. Салбарын удирдлагын манлайллыг хангах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хийх;

2.5.4.2. Санхүү, хөрөнгө оруулалтын төсвийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх;

2.5.4.3. Үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, чадавхыг бэхжүүлэх.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Агентлагийн үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус агентлаг тодорхойлж, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг болон албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгах замаар хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Агентлагийн үйл ажиллагааны стратегийг дараах загвараар тодорхойлж байна.



Гурав. Агентлагийн бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

### 3.1 Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Агентлагийн бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад дараах зарчмыг баримтална:

-агентлагийн үйл ажиллагааны стратегийн зорилтыг бүтцэд тусгах (тус агентлагийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх)

-эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, тухайн нэгж ямар асуудал эрхэлдэг, тухайн албан тушаалтан ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байхын зэрэгцээ харьяа байгууллагын зорилт, чиг үүрэгтэй давхардахгүй байх)

-үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх (агентлагийн бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх)

-бүтцийн хувьд энгийн байх (агентлагийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл гурваас доошгүй шат дамжлагатай байх)

-тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зохистой тэнцвэрийг хангах)

-хангалттай чадавх, бодит ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлж, дайчлахад чиглэсэн, хэрэгжихүйц, ажиллах чадвартай байх)

-улс төржихгүй байх (мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй байх)

### 3.2 Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Агентлагийн бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим болон үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус агентлагийн үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг дараах байдлаар үзүүлж байна.



## Усны газрын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



### 3.3 Зохион байгуулалтын бүтэц

Усны газрын үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус агентлагийн зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг дараахь байдлаар тодорхойлно.

#### 3.3.1. Усны нөөц, төлөвлөлтийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг.

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд усны нөөцийн хайгуул, зураг төсөл, судалгааны төлөвлөгөө боловсруулах, гадаргын усны нөөцийг хомсдох бохирдохоос хамгаалах хууль эрх зүйн орчныг хэрэгжүүлэх, хайгуул, судалгааны ажлын явцад хяналт тавих, хайгуулын зардлыг нөхөн төлүүлэх, улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, уг төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, усны тоо бүртгэл, усны мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, усны төлөв байдалтай холбоотой мэдээллээр иргэн, хуулийн этгээдийг хангах, усны сан бүхий газар, хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих,

#### 3.3.2 Ус ашиглалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг.

Энэ нэгж нь стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг ус ашиглалтын чиглэлээр мэргэжил, арга зүйгээр хангах, хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах болон усаар хангагч байгууллагад дүгнэлт гаргах, сав газрын захиргаа, байгаль орчны газрын гаргасан ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээний биелэлтэд хяналт тавих, бэлчээрийн усжуулалт, услалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд дүгнэлт гаргах;

3.3.3. Усны чанар, хяналтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг.

Энэ нэгж нь стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх, ус ашиглагч, хэрэглэгч, хаягдал усны дүгнэлт гаргаж буй байгууллагыг хаягдал усны талаарх мэргэжил, арга зүйгээр хангах, хоногт 50 шоометрээс их, эсхүл аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид дүгнэлт гаргах, зөвшөөрөл, гэрээ, төлбөрийн орлого, зарцуулалтад хяналт тавих, ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл, стандартын хэрэгжилтэд хяналт тавих;

3.3.4. Захиргаа, санхүүгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг.

Энэ нэгж нь стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд салбарын удирдлагын манлайллыг хангах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, чадавхыг бэхжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, усны чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагуудтай гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, хилийн усны гэрээ хэлэлцээр, холбогдох конвенцын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаанд дотоод хяналт тавих, санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөж, хэрэгжүүлэх, төсвийн санхүүжилтийг үр ашигтай зарцуулах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

-УСНЫ ГАЗАР-

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗРЫН  
СҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

